

БАТЛАВ:
НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР,
СПОРТЫН ГАЗРЫН ДАРГА

Ж.ГАНБОЛД
2015 оны 05 сар 15-ны өдөр



БАТЛАВ:
“ИХ ТАЛЫН ДУУЛИАН” ТТБ-ЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Б.ТЭРБААТАР
2015 оны 05 сар 15-ны өдөр



№07

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

Нэг талаас Нийслэлийн Биеийн тамир, спортын газар /цаашид “Захиалагч” гэнэ/ түүнийг төлөөлж ахлах мэргэжилтэн А.Болдмаа, нөгөө талаас “Их Талын дуулиан” ТТБ (цаашид “Гүйцэтгэгч” гэнэ), түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал Б.Тэрбаатар нар харилцан тохиролцож дараахь гэрээг байгуулав.

1. Нийтлэг заалт

- 1.1 “Улаанбаатар марафон - 2015” олон улсын гүйлтийг зохион байгуулахад шаардлагатай гүйгчдийн Улаанбаатар марафоны лого, ерөнхий зохион байгуулагчдын лого бүхий футболк, малгай, медаль медалионыг бэлтгэн нийлүүлэх үүрэг хүлээнэ.
- 1.2. Захиалагч, Гүйцэтгэгчийн нийлүүлсэн барааг хүлээн авч үнийг төлнө.
- 1.3. Гүйцэтгэгч барааг тохиролцсон барааны нэрийн жагсаалтын дагуу хийж хүлээлгэн өнгө.
- 1.4. Захиалагч нь барааг хүлээн авах хугацааг гүйцэтгэгчтэй харилцан тохиролцоно.

2. Бараа бэлтгэн нийлүүлэх байгууллага

- 2.1. Захиалагч Гүйцэтгэгчид бэлтгэн нийлүүлэх барааны талаарх мэдээллийн 05 дугаар сарын 25-ны дотор хүргүүлнэ.
- 2.2. Захиалагч бэлтгэн нийлүүлэх барааны материал өнгө загварыг үзэж бэлтгэн нийлүүлэх хугацаа эхлэхээс 7 хоногийн өмнө буцааж өгнө.
- 2.3. Шаардлагатай бол Гүйцэтгэгч, Захиалагчтай тохиролцсон хугацаа, хэмжээгээр нэмэлт барааг бэлтгэн нийлүүлнэ.
- 2.4. Захиалагч тодорхойлолт – жагсаалтад заасан барааг татгалзах, эсвэл хугацааг өөрчлөх эрхтэй бөгөөд энэ тухайгаа Гүйцэтгэгчид бэлтгэн нийлүүлэх хугацаанаас 3 хоногийн өмнө заавал мэдэгдэнэ.
- 2.5. Захиалагчид Гүйцэтгэгч тодорхойлолт – жагсаалтад заасан болон барааг бэлтгэн нийлүүлэхтэй холбогдсон төрөл бүрийн үйлчилгээ үзүүлнэ.

3. Тооцоо хийх журам

- 3.1. Төлбөрийг талуудын харилцан тохиролцсоны дагуу 480 ш футболкийг нэг бүрийн үнийг 10000 төгрөгөөр, 480 ш малгайг нэг бүрийн үнийг 5000 төгрөгөөр, 400 ширхэг медаль медалионыг нэг бүрийн үнийг 10000 төгрөгөөр бодож төлнө.

3.2. Гүйцэтгэгч тал Захиалагчид урьдчилгаа төлбөр төлөхгүй бөгөөд бараагаа бүрэн хүлээн авсны дараа барааны үнэ 11 200 000 /арван нэгэн мянга хоёр зуун мянган/төгрөгийг 100 хувь төлж барагдуулна.

4. Нэмэлт нөхцөл

4.1. Бараа материалын холбогдолтой ямар нэгэн санал, өөрчлөлтийг 2 тал харилцан тохиролцож тухай бүр ажлын бараа материалыг бэлтгэн нийлүүлэхээс 3 хоногийн өмнө зохицуулна.

5. Эд хөрөнгийн хариуцлага

5.1. Дутуу буюу шаардлага хангаагүй бараа бэлтгэн нийлүүлсэн, эсвэл хугацаа хожимдуулсан бол Гүйцэтгэгч тухайн шаардлага хангаагүй барааг шинэчлэх буюу дутуу барааг бүрэн гүйцэт болгох үүрэг хүлээнэ.

(дүнг үсгээр)

5.2. Талууд үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол нөгөө талд учирсан хохирлыг бүрэн хэмжээгээр нөхөн төлнө.

6. Маргааныг шийдвэрлэх

6.1. Гэрээтэй холбоотой маргааныг талууд харилцан тохиролцох замаар шийдвэрлэнэ.

6.2. Хэрэв маргаантай асуудлаар Талууд тохиролцоонд хүрч чадахгүй тохиолдолд бүх маргааныг Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Үндэсний Арбитрт түүний Арбитрын хэрэг шийдвэрлэх дүрмийн дагуу Монгол Улсад эцэслэн шийдвэрлэнэ. Арбитрын шийдвэр Талуудад эцсийн бөгөөд заавал биелүүлэх шийдвэр байна.

7. Гэрээний үйлчлэх хугацаа

7.1. Гэрээ нь 2015 оны 05 сарын 20-ны өдрөөс хүчин төгөлдөр болж 2015 оны 06 сарын 15-ны өдөр хүртэл үйлчилнэ.

8. Талуудын хаяг

Захиалагч тал:

Нийслэлийн Биеийн тамир,
спортын газрын ахлах мэргэжилтэн
А.Болдмаа

Гарын үсэг: _____

Гүйцэтгэгч тал:

“Их Талын дуулиан” ТТБ-ын
Гүйцэтгэх захирал
Б.Тэрбаатар

Гарын үсэг: _____

2015 оны 05 дугаар сарын 25-ны өдөр